

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/151/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



БАЯНХОНГОР СУМЫН  
ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.ОНОНХҮҮ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.06 № 2/01

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 3,866,495.0 мянга, орон нутгийн төсвөөс баталсан 673 мянган төгрөгийн төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлогоор 16,051.2 мянган төгрөгийг оруулан, баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Сургуулийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, орон нутгийн санхүүжилтийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан, дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн орлогыг цаг тухайд нь нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, сургуулийн захирал өөртөө шийдвэр гаргаж үр дүнгийн урамшуулал авсан зэрэг алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

5020113

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолтоор баталсан чиг үүрэг, санхүүгийн сахилга бат, гүйцэтгэл, үр дүнг Баянхонгор аймгийн Боловсролын газраас 93.21 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>480,733,876.59</u></b>	<b><u>391,446,868.85</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	255,965,794.38	174,082,831.14
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	255,965,794.38	174,082,831.14
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	255,965,794.38	174,082,831.14
31211	Төрийн сангийн харилцах	255,965,794.38	174,082,831.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	224,768,082.21	217,364,037.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	86,495,448.71	91,848,848.71
35110	Тусгай зориулалттай материал	83,074,948.71	89,634,848.71
35130	Эм боох материал	3,420,500.00	2,214,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	138,272,633.50	125,515,189.00
35410	Бичиг хэргийн материал	1,523,500.00	1,968,220.00
35420	Аж ахуйн материал	8,131,257.00	8,491,977.00
35450	Барилгын засварын материал	13,630,445.00	941,200.00
35470	Бусад хангамжийн материал	114,987,431.50	114,113,792.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,333,340,697.31</u></b>	<b><u>5,372,909,685.44</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,333,340,697.31	5,372,909,685.44
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,687,125,697.31	4,726,804,685.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,935,161,872.36	4,971,432,487.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-690,717,712.26	-870,170,045.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	505,653,538.10	723,547,998.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-238,184,909.89	-286,030,252.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	306,346,496.57	300,367,066.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-210,113,748.57	-196,682,329.63
39217	Ном	78,980,161.00	84,339,761.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	646,215,000.00	646,104,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	646,765,000.00	646,215,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-110,000.04
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,814,074,573.90</u></b>	<b><u>5,764,356,554.29</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>66,669,864.89</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	66,669,864.89
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	66,669,864.89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.59
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,922,116.30
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	63,747,748.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	63,747,748.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>5,814,074,573.90</u></b>	<b><u>5,697,686,689.40</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,814,074,573.90	5,697,686,689.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,468,610,681.55	1,468,610,681.55
51101	Өмч: - төрийн	1,468,610,681.55	1,468,610,681.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,310,694,248.30	2,194,306,363.80
51210	Өмнөх үеийн үр дүн	2,310,694,248.30	2,310,694,248.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-116,387,884.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,034,769,644.05	2,034,769,644.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,814,074,573.90</u></b>	<b><u>5,764,356,554.29</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,772,635,423.40</b>	<b>4,808,355,266.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,388,678,623.40</b>	<b>268,559,366.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,388,678,623.40	268,559,366.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,935,300.00	16,051,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	14,306,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,935,300.00	1,744,400.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	00.00	8,750,000.00
1200177	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	00.00	243,758,166.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,383,956,800.00</b>	<b>4,539,795,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,847,773,600.00</b>	<b>3,866,495,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,847,773,600.00	3,866,495,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>536,183,200.00</b>	<b>662,696,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	536,183,200.00	662,696,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,508,149,173.60</b>	<b>4,924,743,150.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,508,149,173.60</b>	<b>4,924,743,150.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,367,061,933.01</b>	<b>4,734,045,700.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,003,243,982.28</b>	<b>2,999,670,776.81</b>
210101	Үндсэн цалин	1,386,569,991.01	1,870,044,413.81
210102	Нэмэгдэл	545,949,349.27	952,053,836.00
210104	Урамшуулал	70,724,642.00	177,572,527.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>249,775,900.83</b>	<b>379,515,156.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	172,033,719.90	258,022,856.07
210202	Тэтгэмжийн даатгал	19,824,982.42	30,373,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,580,626.76	15,186,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,939,466.99	15,186,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,397,104.76	60,746,100.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>546,119,529.41</b>	<b>640,619,016.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	28,343,998.35	35,489,151.96
210302	Түлш, халаалт	446,757,381.06	535,229,864.34
210303	Цэвэр, бохир ус	71,018,150.00	69,900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>118,417,606.12</b>	<b>67,687,060.00</b>
210401	Бичиг хэрэг	33,999,693.00	14,520,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,725,385.40	170,186.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,575,485.00	21,004,479.00
210408	Бараа материал акталсны зардал	70,017,042.72	30,341,974.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>98,314,645.00</b>	<b>116,181,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,510,300.00	227,100.00
210502	Хоол, хүнс	90,804,345.00	115,954,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,790,115.00</b>	<b>38,223,713.00</b>
210604	Урсгал засвар	33,790,115.00	38,223,713.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,060,772.30</b>	<b>39,942,491.95</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,905,300.00	867,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,155,472.30	39,074,691.95
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>300,339,382.07</b>	<b>452,205,985.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,606,473.00	46,889,309.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	25,589,898.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	270,732,909.07	379,726,777.87
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	141,087,240.59	190,697,450.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	137,023,550.00	180,093,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	108,487,450.00	121,008,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,536,100.00	59,084,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,063,690.59	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,063,690.59	0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,264,486,249.80</b>	<b>-116,387,884.50</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,264,486,249.80</b>	<b>-116,387,884.50</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,440,892,100.00</b>	<b>4,545,243,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>56,935,300.00</b>	<b>16,051,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	56,935,300.00	16,051,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,935,300.00	16,051,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	14,306,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,935,300.00	1,744,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,383,956,800.00</b>	<b>4,529,191,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,847,773,600.00	3,866,495,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,847,773,600.00	3,866,495,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	536,183,200.00	662,696,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	536,183,200.00	662,696,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,155,178,951.81</b>	<b>4,515,336,211.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,155,178,951.81</b>	<b>4,515,336,211.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,014,091,711.22</b>	<b>4,335,242,761.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,003,243,982.28	2,999,670,776.81
210101	Үндсэн цалин	1,386,569,991.01	1,870,044,413.81
210102	Нэмэгдэл	545,949,349.27	952,053,836.00
210104	Урамшуулал	70,724,642.00	177,572,527.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	249,775,900.83	379,515,156.07
210201	Тэтгэврийн даатгал	172,033,719.90	258,022,856.07
210202	Тэтгэмжийн даатгал	19,824,982.42	30,373,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,580,626.76	15,186,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,939,466.99	15,186,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,397,104.76	60,746,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	546,119,529.41	637,696,900.00
210301	Гэрэл, цахилгаан	28,343,998.35	32,567,035.66
210302	Түлш, халаалт	446,757,381.06	535,229,864.34
210303	Цэвэр, бохир ус	71,018,150.00	69,900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	250,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	90,804,345.00	115,954,400.00
210502	Хоол, хүнс	90,804,345.00	115,954,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,999,980.00	25,000,000.00
210604	Урсгал засвар	25,999,980.00	25,000,000.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,772,947.72	41,482,491.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,905,300.00	867,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,867,647.72	40,614,691.95
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,125,025.98	135,923,036.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,174,140.98	108,131,346.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,950,885.00	27,791,690.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>141,087,240.59</b>	<b>180,093,450.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	137,023,550.00	180,093,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	108,487,450.00	121,008,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,536,100.00	59,084,800.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,063,690.59	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,063,690.59	00.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>285,713,148.19</b>	<b>29,906,888.76</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>94,282,800.00</b>	<b>111,789,852.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>94,282,800.00</b>	<b>111,789,852.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	94,282,800.00	111,789,852.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	94,282,800.00	111,789,852.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-94,282,800.00</b>	<b>-111,789,852.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	191,430,348.19	-81,882,963.24
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	64,535,446.19	255,965,794.38
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	255,965,794.38	174,082,831.14

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.5	4,549,588,324.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.5	4,549,588,324.10
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	2,310,694,248.30	5,814,074,573.90
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	2,310,694,248.30	5,814,074,573.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	2,310,694,248.30	5,814,074,573.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-116,387,884.50	-116,387,884.50
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	2,194,306,363.80	5,697,686,689.40

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,801,191,400.00	4,627,126,063.24	174,065,336.76	96.37
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,801,191,400.00	4,627,126,063.24	174,065,336.76	96.37
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,605,624,000.00	4,447,032,613.24	158,591,386.76	96.56
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,119,738,400.00	2,999,670,776.81	120,067,623.19	96.15
210101	Үндсэн цалин	2,131,962,000.00	1,870,044,413.81	261,917,586.19	87.71
210102	Нэмэгдэл	861,357,700.00	952,053,836.00	-90,696,136.00	110.53
210104	Урамшуулал	126,418,700.00	177,572,527.00	-51,153,827.00	140.46
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	389,967,100.00	379,515,156.07	10,451,943.93	97.32
210201	Тэтгэврийн даатгал	265,177,600.00	258,022,856.07	7,154,743.93	97.30
210202	Тэтгэмжийн даатгал	31,197,300.00	30,373,000.00	824,300.00	97.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,598,700.00	15,186,600.00	412,100.00	97.36
210204	Ажилгүйдлийн даатгал	15,598,700.00	15,186,600.00	412,100.00	97.36
210205	Эрүүл мэндийн даатгал	62,394,800.00	60,746,100.00	1,648,700.00	97.36
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	637,696,900.00	637,696,900.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	32,100,000.00	32,567,035.66	-467,035.66	101.45
210302	Түлш, халаалт	535,696,900.00	535,229,864.34	467,035.66	99.91
210303	Цэвэр, бохир ус	69,900,000.00	69,900,000.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	141,100,400.00	115,954,400.00	25,146,000.00	82.18
210502	Хоол, хүнс	141,100,400.00	115,954,400.00	25,146,000.00	82.18
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,000,000.00	25,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	00.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	66,236,000.00	66,235,943.95	56.05	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	867,800.00	867,800.00	00.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,368,200.00	65,368,143.95	56.05	100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	225885200.00	222959436.41	2,925,763.59	98.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	198,093,500.00	195,167,746.41	2,925,753.59	98.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,791,700.00	27,791,690.00	10.00	100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	195567400.00	180093450.00	15,473,950.00	92.09
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	195,567,400.00	180,093,450.00	15,473,950.00	92.09
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,482,600.00	121,008,650.00	15,473,950.00	88.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,084,800.00	59,084,800.00	00.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,801,191,400.00	4,545,243,100.00	255,948,300.00	94.67
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,866,495,000.00	3,866,495,000.00	00.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,866,495,000.00	3,866,495,000.00	00.00	100.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	662,696,900.00	662,696,900.00	00.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	662,696,900.00	662,696,900.00	00.00	100.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	271,999,500.00	16,051,200.00	255,948,300.00	5.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,867,800.00	14,306,800.00	-5,439,000.00	161.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,183,400.00	1,744,400.00	5,439,000.00	24.28
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	255,948,300.00	00.00	255,948,300.00	0.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	00.00	100.00
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	126.00	114.00	12.00	90.48
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	99.00	88.00	11.00	88.89
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00	00.00	100.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1,256.00	1,256.00	00.00	100.00

630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,256.00	1,256.00	00.00	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,256.00	1,256.00	00.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	126.00	114.00	12.00	90.48
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	85.00	75.00	10.00	88.24
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	01.00	01.00	00.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	01.00	01.00	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	39.00	37.00	02.00	94.87

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль нь "Эрүүл чийрэг бие бялдартай, эрдэм мэдлэгийг эрхэмлэсэн, хүүхэд бүрт тэгш, хүртээмжтэй боломж олгосон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хамт олноороо хүмүүнлэг, оюунлаг, чадварлаг иргэнийг төлөвшүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь 2024 онд 9 зорилтыг дэвшүүлж, нийт 114 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг захирал Л.Ононхүү Ц, 2 дугаар гарын үсгийг 2024 оны 1-3 дугаар сард нягтлан бодогч Ж.Янжмаа, 4-12 дугар сард нягтлан бодогч Б.Шүрсайхан нар зурж, нярваар Д.Идэрханд, Г.Нацаг-Юмсүрэн нар ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Боловсролын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023.06.16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Сангийн сайдын 2024 оны 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайалнгийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар Дотоод хяналт шалгалтын албыг нь шинэчлэн

байгуулсан бөгөөд тус онд хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, 3 чиглэлээр дотоод хяналтыг хэрэгжүүлж, оны эцэст тайлагнасан байгаа тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,718.0 мянган төгрөгөөр буюу 0.86 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	255,965.79	174,082.83	(81,882.96)
Бараа материал	224,768.08	217,364.04	(7,404.04)
Үндсэн хөрөнгө	6,472,907.07	6,725,902.31	252,995.25
Хуримтлагдсан элэгдэл	(1,139,566.37)	(1,352,992.63)	(213,426.26)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,814,074.57</b>	<b>5,764,356.55</b>	<b>(49,718.02)</b>
Өр төлбөр	-	66,669.86	66,669.86
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,814,074.57	5,697,686.69	(116,387.88)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,814,074.57</b>	<b>5,764,356.55</b>	<b>(49,718.02)</b>

*Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансад нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тус байгууллагын төсөвт урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 255,965.7 мянган төгрөгөөр баталсан, оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 174,082.8 мянган төгрөг болж өмнөх оноос 81,882.9 мянган төгрөгөөр буурсан нь тухайн жилийн батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 7,404.0 мянган төгрөгөөр буурч, 217,364.0 мянган төгрөг болсон нь сургуулийн захирлын 2024 оны А/35, А/61 дүгээр тушаалуудаар 30,341.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн үндсэн хөрөнгө өмнөх оноос 252,995.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 175,537.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн засвар, аймгийн ИТХ-аас шилжүүлсэн дэлгэцийг үнэ төлбөргүй бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн аймгийн БСУГ-аас өгсөн зөөврийн компьютер, "Монголын цахилгаан холбоо" ХХК-аас өгсөн интернетийн холболтын төхөөрөмж зэрэг хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд өглөгтэй гарсан нь Боловсролын ерөнхий газрын БАБСЭМС/015/001 дугаартай ерөнхий гэрээний дагуу 2024-2027 онд төлөгдөж дуусах 84,997.0 мянган төгрөгийн цахим тоног төхөөрөмжийг орлогод бүртгэж, 2024 онд төлөгдөх 21,249.3 мянган төгрөгийг төлж, дараагийн онд төлөх 63,747.7 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 116,387.9 мянган төгрөгөөр хасагдсан нь тус сургууль аймгийн ОНӨГ-т санхүүгийн тайланд бүртгэлтэй үлдэх өртөг нь 0 болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлт хүргүүлсний дагуу аймгийн ОНӨГ-аас 2024.01.09-ний өдөр А/08 дугаар бичгээр анхны өртгийг нөхсөн 126,546.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, бүртгэлээс хасан, шинээр үнэлгээ хийж, ашиглах хугацааг тогтоосны дагуу 120,978.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж хөрөнгөд бүртгэснээр Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,697,686.7 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант оны батлагдсан төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлыг 714,685.5 мянга, улсын төсвөөс санхүүжих зардлыг 3,166,550.3 мянга, нийт 3,881,235.8 мянган төгрөгөөр төсөвлөснөөс эрх бүхий дээд газраас цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлэх зардлыг бууруулж, 2024 оны төсвийг улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийг 2,777,217.6 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 659,465.9 мянга, нийт 3,436,683.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийг 3,5,6,9,10,11,12 дугаар саруудад өөрчлөлт оруулж, 3,866,495.0 мянган төгрөгийн санхүүжилтээр баталсан бол орон нутгаас олгох санхүүжилтийг 10,11 дүгээр сард өөрчлөлт оруулж, нийт 662,696.9 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 16,051.2 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр гүнзгийрүүлсэн ангийн төлбөр, спортын төрөлжсөн сургалтын төлбөрийн орлогоор 14,306.8 мянга, цайны газрын түрээсийн орлого, тендерийн баримт бичгийн үнийн орлогоор 1,744.0 мянган төгрөг төвлөрсөн байна.

Баталсан төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,627,126.1 мянган төгрөг буюу нийт төлөвлөсөн зардлын 96.3 хувьтай үйл ажиллагаа явуулсан, оны эцэст зардлын хэмнэлтийн 174,065.3 мянган төгрөг байгууллагын Төрийн сан банк дахь харилцах дансанд үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,119,738.40	2,999,670.78	120,067.62	65.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	389,967.10	379,515.16	10,451.94	8.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	637,696.90	637,696.90	0.00	13.3
2105	Нормативт зардал	141,100.40	115,954.40	25,146.00	2.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000.00	25,000.00	0.00	0.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,236.00	66,235.94	0.06	1.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,885.20	222,959.44	2,925.76	4.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,567.40	180,093.45	15,473.95	4.1
	ДҮН	4,801,191.40	4,627,126.06	174,065.34	

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тус байгууллагад нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль 2024 онд Дотуур байрны хүүхдийн хоолонд шаардлагатай хүнсний материал худалдан авах тендерийн 4 багцаар, сургуулийн үдийн хоолны хүнсний материал худалдан авах тендерийг 4 багцаар зарлаж, 2024.01.18-ны өдөр худалдан авах ажиллагааны сайтад урилгыг нийтэлж, нээлттэй тендер шалгаруулалтыг явуулжээ.

Тендерт шалгарсан “Цагаан дэнжийн хишиг” ХХК, “Далай ээж Баянхонгор” ХХК, “Баян баялаг өргөө” ХХК-тай 2024.02.20-ны өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гэрээнд заасан дүнгээр хийж, бараа материалд нягтлан бодох бүртгэлээр тусгасан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан төсвийн 3,867,402.7 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 19,337.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 11,602.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитыг “Номгон аудит” ХХК-ийн аудитор О.Мандах гүйцэтгэж, аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

## **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн дотуур байранд аймгийн Политехникийн коллежийн 60 оюутан сурагч байрлаж байгаагаас тогтмол зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс давах эрсдэлтэйг анхаарах нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,531.7 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад бараа материал, үндсэн хөрөнгө, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Нягтлан бодох бүртгэлд 2013.01.01-ний өдөр орлогоор бүртгэсэн 37,600.8 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр нь бүртгэсэн нь Иж бүрэн байх Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул бөөн дүнгээр авсан номыг нэр, төрөл, тоо ширхэгээр задалж залруулсан.
2. Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй, хөрөнгийг ашиглах хугацааг сунгаж дахин үнэлсэн албан бичгийг аймгийн ОНӨГ-аас 2024.01.09-ний өдөр ирүүлсэн байхад 120,978.7 мянган төгрөгийн дахин үнэлсэн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд 2024 оны 12 дугаар сард орлогод авснаас тус хөрөнгүүдэд тайлант жилд элэгдэл бодогдож, тайлант жилийн зардлаар бүртгэгдээгүй нь Тасалбар болголт, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй тул дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн орлогыг 2024 оны 01 дүгээр сараар залруулан бүртгэж, тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрүүлэн залруулсан.
3. Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг 10,604.0 мянган төгрөгөөр илүү олгосныг санхүүжилтээр бүртгэж, оны эцэст татан төвлөрүүлснээр буруу бүртгэсэн нь Үнэлгээ ба хуваарилалт, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүжилтийг мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулсан.
4. Тайлант жилд орсон спортын төрөлжсөн сургалтын төлбөрийг туслах үйл ажиллагааны орлогоор, тендерийн баримт бичгийн орлого, цайны газрын түрээсийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн нь Ангилал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд орлогыг залруулан бүртгэсэн.

Аудитаар нийт 98,859.1 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг 97,759.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн нийт алдаа, зөрчлийн дүн 1,100.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Сургуулийн захирлын 2024.12.17-ны өдрийн шийдвэрээр оны эцсийн үр дүнгийн урамшуулал олгохдоо сургуулийн захиралд 1,100.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүүгээр үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн гал тогоог түрээслэгч иргэн Б.Раднаабямба, сургуулийн захирал Л.Ононхүү, аймгийн ОНӨГ-ын дарга Ц.Идэрмөнх нарын 2024.09.03-ны өдөр байгуулсан 001 дугаар бүхий "Орон нутгийн өмчийн гэрээ"-ний дагуу түрээслэгч иргэний ашигласан цахилгаан, цэвэр бохир усны төлбөрийг тус иргэнээр төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн гал тогоог түрээслэгч иргэн Б.Раднаабямба, сургуулийн захирал Л.Ононхүү, аймгийн ОНӨГ-ын дарга Ц.Идэрмөнх нарын 2024.09.03-ны өдөр байгуулсан 001 дугаар бүхий "Орон нутгийн өмчийн гэрээ"-ний 3.4, 3.6, 3.9, 7.3 заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн гал тогоонд цахилгаан, усны тоолуурыг суурилуулж, ханган нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн. нэхэмжлэлийн дагуу түрээслэгчээр бүрэн төлүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн шилэн дансанд байгууллагын даргын 2024 онд хөрөнгө захиран зарцуулах 8,595.2 мянган төгрөгийн 3 тушаал, 82,158.9 мянган төгрөгийн 4 гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,005.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах албан шаардлагыг өглөө.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлд 2013.01.01-ний өдөр орлогоор бүртгэсэн 37,600.8 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр нь бүртгэсэн байна.	1	37,600.8			1	37,600.8	1	37,600.8				
Дахин үнэлсэн хөрөнгийг орлогод авах албан бичиг аймгийн ОНӨГ-аас 2024.01.09-ний өдөр ирсэн байхад 12 дугаар сард орлогод авсан нь тайлант жилд элэгдэл тооцоогүй байна.	1	120,978.7			1	120,978.7	1	120,978.7				
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг 10604.0 мянган төгрөгөөр илүү олгосныг санхүүжилтээр бүртгэж, оны эцэст татан төвлөрүүлснээр буруу бүртгэсэн байна.	1	10,604.0			1	10,604.0	1	10,604.0				
Тайлант жилд орсон гүнзгийрүүлсэн ангийн төлбөр, спортын төрөлжсөн сургалын төлбөр, тендерийн баримт бичгийн орлогыг зөрүүтэй тайлагнасан.	1	4,348.2			1	4,348.2	1	4,348.2				
<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>173,531.7</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>173,531.7</b>	<b>4</b>	<b>173,531.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сургуулийн захирлын 2024.12.17-ны өдрийн шийдвэрээр өөртөө 1,100.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан байна.	1	1,100.0	1	1,100.0								
Сургуулийн захирал, аймгийн ОНӨГ-ын дарга, сургуулийн цайны газрыг түрээслэгч иргэн нарын хооронд 2024.09.03-ны өдөр байгуулсан 001 дугаар бүхий "Орон нутгийн өмчийн гэрээ"-нд заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-			1	-						
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>1,100.00</b>	<b>1</b>	<b>1,100.00</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансанд байгууллагын даргын 8,595.2 мянган төгрөгийн 3 тушаал, 82,158.9 мянган төгрөгийн 4 гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,005.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	97,759.1			1	97,759.1		
Дүн	1	97,759.1	0	0	1	97,759.1	0	

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 04/09/40560233/БАА-  
2025/159/АА-СТА-ТМЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн захирал нь албан хаагчидад үр дүнгийн урамшуулал олгох 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Б/132 дугаар тушаалд өөрийгөө оруулан 1,100,000 (Нэг сая нэг зуун мянган) төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүүгээр 1,100,000 (Нэг сая нэг зуун мянган) төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нөхөн

5050001

төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.


2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүү, нягтлан бодогч Б.Шүрсайхан нарт даалгав<sup>2,3</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР

**Б.ДОЛЖМАА**



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 01/1/АОСБ025 8/БНТ  
2025/151/АТТ - СТА - ТУБ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим системд байгууллагын даргын 2024 онд хөрөнгө захиран зарцуулах 8,595,203 (Найман сая таван зуун ерэн таван мянга хоёр зуун гурван) төгрөгийн 3 тушаал, 82,158,902 (Наян хоёр сая нэг зуун тавин найман мянга есөн зуун хоёр) төгрөгийн 4 гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,005,079 (Долоон сая таван мянга далан есөн) төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

5040001

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 8,595,203 (Найман сая таван зуун ерэн таван мянга хоёр зуун гурван) төгрөгийн 3 тушаал, 82,158,902 (Наян хоёр сая нэг зуун тавин найман мянга есөн зуун хоёр) төгрөгийн 4 гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,005,079 (Долоон сая таван мянга далан есөн) төгрөгийн 1 зарлагын гүйлгээг нөхөн мэдээлж, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 03 дугаар сарын 05-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүү, нягтлан бодогч Б.Шүрсайхан нарт даалгав<sup>2, 3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 02/2/А0560233/БНА  
2025/159/НА -СТА ТУС

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн гал тогоог түрээслэгч иргэн Б.Раднаабямба, сургуулийн захирал Л.Ононхүү, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарын 2024.09.03-ны өдөр байгуулсан 001 дугаар бүхий "Орон нутгийн өмчийн гэрээ"-ний дагуу ашигласан цахилгаан, цэвэр бохир усны төлбөрийг тус түрээслэгчээр төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Иргэний хуулийн 292.3.Талууд тохиролцсон бол нэмэлт зардлын төлбөрийг нэгэн адил төлнө" заалт болон Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн гал тогоог түрээслэгч иргэн Б.Раднаабямба, сургуулийн захирал Л.Ононхүү, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарын 2024.09.03-ны өдөр байгуулсан 001 дугаар бүхий "Орон нутгийн өмчийн гэрээ"-ний 3.4, 3.6, 3.9, 7.3 заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

5040004

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сургуулийн гал тогоонд цахилгаан, усны тоолуурыг суурилуулж, ханган нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу түрээслэгчээр бүрэн төлүүлэх, албан шаардлагыг хэрэгжүүлсэн талаарх нотлох баримтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүү, нягтлан бодогч Б.Шүрсайхан нарт даалгав<sup>2, 3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН!**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно